

МОНГОЛ УЛСЫН НОМ ХЭВЛЭЛ ӨВӨР МОНГОЛД ХЭВЛЭГДЭН ТАРХСАН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ

*Н.Улаан-Од**

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд 1946-1980 оны хооронд Монгол Улсын ном хэвлэл, манай оронд орчуулагдан, хэвлэгдсэн түүхэн хөгжлийн тухай ерөнхийлөн танилцуулахыг хичээв.

Түлхүүр үг: Монгол Улс, зохиол бүтээл, ном хэвлэл, орчин үе, уран зохиол, Өвөр монгол.

Монгол Улсын орчин үеийн уран зохиолын нөлөө 1946-1966 оны хооронд манай оронд маш хүчтэй түрэн орж ирсэн алтан үе байсан бөгөөд одоо ч тэр үеийг давж гарах уран зохиол гараагүй байна гэж зарим эрдэмтэн судлаачид үздэг.

1946-1966 оны хооронд БНХАУ-д хамгийн их тархсан Монгол Улсын ном хэвлэлийн бүтээлүүд нь голдуу Б.Содном, Ц.Дамдинсүрэн, Д.Нацагдорж, Б.Ринчин, Ц.Лодойдамба, Б.Пүрэвдорж, Д.Сэнгэ, Р.Чойном, М.Гаадамба зэрэг ахмад нэгэн үеийнхний зохиол бүтээлүүд болно. 1934 онд Б.Содномын туурвисан “Монголын утга зохиолын түүхчилсэн төлөв” хэмээх өгүүлийг 1954 онд манай улсад “Монголын уран зохиолын хөгжлийн түүх” гэсэн нэртэйгээр хятад хэл дээр орчуулан, Хятадын соёл амьдралын хэвлэлийн хорооноос 4000 ширхэг хэвлэн гаргасан байна.

Б.Содномын туурвисан уг уран зохиолын түүхийн номыг Монгол Улсын хамгийн анхны уран зохиолын түүхийн ном гэж дийлэнх судлаачид үздэг юм. Уг номонд Монголын нийт уран зохиолын хөгжлийн түүхийг гурван үе шатанд хуваан өгүүлж, 1200 он буюу 1206-1691 оныг Монголын уран зохиолын үүслийн үе, 1691-1921 оныг Манж Чингийн засгийн эрхшээл дэх өөртөө засах үеийн монгол уран зохиол ба 1921-1946 оныг тусгаар тогтнолын дараах монгол уран зохиол гэж хуваасан байна.

1957 онд Өвөр Монголын ардын хэвлэлийн хорооноос хэвлэсэн Ц.Дамдинсүрэнгийн “Монголын уран зохиолын түүх” номонд 13-р зуунаас 16-р зууны Монголын уран зохиолыг голчлон танилцуулав. Уг номонд Монголын эртний алдарт зохиолуудын агуулга, үзэл санаа, уран сайхны онцлог, уран зохиол ба аман зохиолын харилцаа холбоо, Монгол болон хөрш зэргэлдээ орнуудын соёл боловсролын харьцаа холбоог тодорхойлсон байна.

1956 онд М.Гаадамбын “Уран зохиолын сэдвийн тухай” өгүүлийг Өвөр монголын өдрийн сонинд нийтэлсэн бөгөөд 1960 онд түүний “Утга зохиолын онолын товч” хэмээх номыг Өвөр Монголын ардын хэвлэлийн

* Н.Улаан-Од - Өвөр Монголын их сургуулийн дэд профессор

хорооноос хэвлэн гаргасан байна. Уг ном бол Монголын орчин үеийн түүхэн дэх хамгийн анхны утга зохиолын онолын ном бөгөөд мөн БНХАУ-д хэвлэгдсэн Монгол Улсын орчин үеийн хамгийн анхны онолын ном юм. Тэр нь “Уран зохиолын мөн чанар”, “Зохиолын тухай сургаал”, “Утга зохиолын тухай явц” гэх гурван бүлгээс бүтжээ.

Өвөр монголын “Монгол түүх хэл бичиг” сэтгүүлийн 1958 оны 1-р хугацаанд Б.Содномын “Монгол шүлгийн арга маяг” хэмээх өгүүллийг нийтэлж, үүнд түүний монгол шүлгийн ерөнхий мэдэгдэхүүн, үечлэл, бадаг, үгийн толгой адгийг холбох тухай, цагаан шүлэг, чөлөөт шүлэг гэх зургаан бүлгийг оруулсан байна. Мөн уг сэтгүүлийн 1958 оны 6-р хугацаанд Ц.Дамдинсүрэнгийн “Монголын уран зохиолын товч өгүүлэл” хэмээх өгүүллийг нийтэлсэн бөгөөд зохиогчийн шинэ уран зохиолын өв уламжлал болсон Монголын эртний уран зохиол болон Энэтхэг, Түвдийн уран зохиол, түүнчлэн Хятадын уран зохиолын хоорондох харьцаа холбоо, үүсэл ирэлт жич нөлөөг өгүүлсэн байдлыг дэлгэрэнгүй танилцуулжээ.

1957 оны Өвөр Монголын “Өнөр цэцэг” сэтгүүлийн 2-р хугацаанд Палягийн “Нацагдоржийн зохиолын сэдэв ба хэлний тухай шүүмж” өгүүлэл нийтлэгдэж, “Нацагдоржийн зохиол бүтээлийн сэдвийн онцлог ба хэлний уран баялгийг тусгай жишээгээр нотлож, түүний уран бүтээлийн сэдэв бол эх орон, ард түмнээ хайрлах, бахархах, хуучны үхширмэл зүйлийг шүүмжлэх, хувьсгалаар төрсөн шинэ зүйлийг магтан дуулах өнгө аяс их байдаг юм гэж дүгнэжээ”. Мөн “Нацагдорж бол төрөлх хэлээ бахдам сайхан мэддэг, төрөлх хэлнийхээ эрхэм нандин үгсийг зохиолдоо чадамгай сайхан хэрэглэж байсан юм. Тэр зохиолдоо монгол хэлээ амьдралыг дүрслэх багаж болгон хэрэглэж чаддаг байсан, ийм учраас түүний зохиол бүтээл утга төгөлдөр, үг хурц байдаг тул уншигчдын сэтгэл зүрхийг үргэлж догдлуулдаг” гэж үнэлсэн юм.

Тавь жараад оны хооронд манай оронд нийтлэгдсэн Монгол Улсын орчин үеийн уран зохиолын тухай шүүмж өгүүллүүд нь, хоёр орны найрсаг харилцааг бэхжүүлэх үүднээс түлхүү анхаарч байсан юм. Мөн тухайн үеийн Монгол Улсын утга зохиолын ерөнхий хөгжил, манай орноос илүү хөгжсөн нь үнэн юм. Иймээс Монгол Улсын ном хэвлэл манай оронд маш ихээр хэвлэгдсэн юм.

Үүнд: роман, өгүүллэг тууж, жүжиг, яруу найргийн түүвэр, бусад зохиолын түүвэр гэх таван төрөлд ангилан хувааж, он дарааллаар нь жагсаавал:

Нэг. Роман:

1. Б.Ринчин: “Үүрийн туяа”. Үндэстний хэвлэлийн хороо. 1953 он, 1957 он, 1980 он.
2. Ц.Лхамсүрэн: “Мамий зөгий хоёр”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1954 он, 1980 он.

3. Ч.Лодойдамба: “Тунгалаг тамир”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1980 он, 1984 он, 1992 он, 1999 он.
4. Д.Намдаг: “Цаг төрийн үймээн”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1983 он, 1997 он.
5. Д.Цамбал: “Амарсанаа”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1985 он.
6. Ж.Пүрэв: “Зүрхний хилэн”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1985 он, 1988 он.
7. Н.Надмид: “Хүлээс алдарсан нь”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1987 он.
8. Д.Цэвэгмид: “Анхны багш”. Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 1988 он.
9. Ш.Нацагдорж: “Мандухай Цэцэн”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1988 он.
10. Л.Түдэв: “Оройгүй сүм”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1990 он.
11. Ж.Пүрэв: “Манан будан”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1990 он, 2000 он.
12. Ж.Сандаг: “Шалдар булдар нас”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1991 он.
13. Ж.Лодой: “Дайн” (дээд, доод дэвтэр). Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1991 он.
14. П.Хорлоо: “Морьманагч”. Үндэстний хэвлэлийн хороо. 1992 он.
15. Дарьсүрэн: “Онцгой эрх” (дээд, доод дэвтэр). Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1992 он.
16. С.Эрдэнэ: “Занабазар”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1992 он, 2009 он.
17. С.Удвал: “Их хувь заяа”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1994 он.
18. Ж.Дорж: “Эрдэнэ засгийн унага”. Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 1994 он.
19. Ж.Пүрэв: “Чулуун хаалга”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1996 он.
20. С.Лочин: “Гал голомт”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1998 он.
21. Ч.Лодойдамба: “Алтайд”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2000 он.
22. Б.Ринчин: “Заан залуудай”. Үндэстний хэвлэлийн хороо. 2002 он.
23. С.Пүрэв: “Цаг цагийн урсгал”. Үндэстний хэвлэлийн хороо. 2002 он.
24. Ж.Пүрэв: “Аянга”. Үндэстний хэвлэлийн хороо. 2002 он.

25. С.Лочин: “Сарныгэрэл”. Үндэстний хэвлэлийн хороо. 2002 он.
26. С.Лочин: “Насны зам”. Үндэстний хэвлэлийн хороо. 2002 он.
27. Ц.Чимэд: “Хавар намар”. Үндэстний хэвлэлийн хороо. 2003 он.
28. М.Тогмид: “Бушуу туулай”. Үндэстний хэвлэлийн хороо. 2003 он.
29. Ж.Баттулга: “Хүүхэн заяа”. Үндэстний хэвлэлийн хороо. 2003 он.
30. Б.Ринчин: “Их нүүдэл”. Үндэстний хэвлэлийн хороо. 2003 он.
31. Б.Пүрэвдорж: “Могой боолт”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2004 он.
32. Р.Чойном: “Тал дахь тулалдаан”. Гонконгийн Тянь Ма хэвлэлийн хороо. 2004 он.
33. Ц.Буянзаяа: “Улаан шувууны жиргээ”. Үндэстний хэвлэлийн хороо. 2004 он.
34. Ж.Пүрэв: “Гэмшил ухаарал”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2005 он.
35. Д.Гармаа: “Харуул Алтай”. Үндэстний хэвлэлийн хороо. 2005 он.
36. Ж.Пүрэв: “Мөхөлтэй өрсөлдсөн он жил”. Үндэстний хэвлэлийн хороо. 2006 он.
37. Ш.Нацагдорж: “Болортоль”. Тянь Ма бичгийн хороо. 2006 он.
38. Ж.Пүрэв: “Эргүүлэг”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2006 он.
39. С.Лочин: “Үргэлжлэлтэй долоон өдөр”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2006 он.
40. Х.Зандрайбайди: “Алая Дамрин”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2006 он.
41. Ж.Пүрэв: “Боржгин цохио доргилоо”. Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо. 2007 он.
42. Д.Цойжамц: “Мянганы хүн Чингис хаан”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2006 он.
43. Д.Цойжамц: “Онцгой тавилан”. Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо. 2007 он.
44. Х.Зандрайбайди: “Хөх чонын удам”. Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо. 2007 он.
45. Ж.Бямба: “Үнэний хорвоо”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2007 он.
46. Ж.Бямба: “Энэрэлгүй хорвоо”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2007 он.
47. Ж.Бямба: “Хорвоогийн өнгө”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2007 он.

48. Ж.Пүрэв: “Зүрхний хилэн”. Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо. 2007 он.
49. Х.Зандрайбайди: “Тэнгэр язгууртан”. Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо. 2008 он
50. Б.Өлзийсүрэн: “Хөлөг баатар Боорчу”. Алсын бараа хэвлэлийн хороо. 2008 он.
51. Д.Гармаа: “Алтан суварга”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2008 он.
52. Л.Чойжилсүрэн: “Дилав хутагт”. Алсын бараа хэвлэлийн хороо. 2008 он.
53. Ц.Доржготов: “Улаан орхимжийн давалгаа”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2009 он.
54. Ж.Пүрэв: “Хувулай хаан”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 2009 он.
55. Л.Пүрэвдорж: “Эрлэгийн бошиг”. Алсын бараа хэвлэлийн хороо. 2009 он.
56. Д.Даржаа: “Эх орны нулимс”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 2009 он.
57. С.Эрдэнэ: “Амьдралын тойрог” (хэвлэлийн хороо болон хэвлэсэн он байхгүй). Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1992 он.
58. Д.Гармаа: “Янагийн халуун”. “Соёмбо принтинг” хэвлэлийн газар. (хэвлэсэн он байхгүй).
59. Д.Гармаа: “Нууцгай хайрын паян”. “Соёмбо принтинг” хэвлэлийн газар. (хэвлэсэн он байхгүй).

Хоёр. Өгүүдэл, тууж:

1. Д.Сэнгэ: “Аюуш”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1950 он, 1955 он, 2008 он.
2. Н.Жамбалсүрэн: “Улаан галстук”. Өвөр Монголын хэвлэлийн товчоо. 1952 он.
3. Лхамсүрэн: “Мардагдашгүй хичээл”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1955 он.
4. Ч.Лодойдамба: “Манай сургуулийнхан”. Үндэстний хэвлэлийн хороо. 1955 он.
5. Бадарч: “Хүжийн гал”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1956 он.
6. Ч.Лодойдамба: “Малгайтай чоно”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1956 он.
7. Д.Тарваа: “Дамдингийнхан”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1956 он.
8. Ц.Уламбаяр: “Энх тайвны манаа”. Үндэстний хэвлэлийн хороо. 1957 он.

9. Бааст Наран: “Моломын хувь заяа”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1957 он.
10. С.Дашдооров: “Сэргэлэн багачууд”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1960 он.
11. “Монголын шилдэг өгүүллэг”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1981 он.
12. Ш.Гаадамба: “Хүүхдийн дунд”. (өгүүллэгийн түүвэр). Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1982 он.
13. С.Эрдэнэ: “Цэнхэрлэн харагдах уул”. Өвөр Монголын сурган хүмүүжлийн хороо. 1983 он.
14. “Монголын шилдэг өгүүллэг”. (дээд, доод дэвтэр). Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1981 он.
15. С.Эрдэнэ: “Уянгын туужууд”. Үндэстний хэвлэлийн хороо. 1990 он.
16. Д.Намсрай: “Хан уулын яргуй”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1998 он.
17. “С.Эрдэнийн шилмэл өгүүллэгүүд”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1998 он, 2000 он.
18. П.Хорлоо: “Говийн хүү”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2000 он.
19. Р.Чойном: “Хар цэцэг”. (дээд, дунд, доод дэвтэр). Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 2001 он.
20. С.Пүрэв: “Элсний нүүдэл”. Тянь Ма ном бичгийн хязгаарт компани. 2004 он.
21. Б.Пүрэвдорж: “Хайрыг ухаархуй”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2007 он.
22. Ц.Мөнх: “Элдэв учрал”. Үндэстний хэвлэлийн хороо. 2008 он.
23. Р.Чойном: “Хүлэг”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2008 он.
24. Н.Мандал: “Бондоохой”. Үндэстний хэвлэлийн хороо. 2008 он.
25. Н.Мандал: “Болсон явдал”. Үндэстний хэвлэлийн хороо. 2008 он.
26. “Монголын сонгомол өгүүллэг”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 2009 он.
27. “Сувдын хэлхээ”. (Монголын шилмэл өгүүллэг). (хэвлэлийн хороо болон хэвлэсэн он жил байхгүй).

Гурав. Жүжиг:

1. Ч.Лодойдамба, Ц.Ойдов нар: “Хуйвилдлага”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1955 он.
2. Б.Цэдэндамба, М.Цэдэндорж нар: “Мэдэхгүйн гай”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1956 он.

3. Д.Нацагдорж: “Учиртай гурван толгой”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1958 он.

Дөрөв. Шүлгийн зохиолын түүвэр:

1. Д.Сэнгэ нар: “Цэрэгт морьтойгоо”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1950 он.
2. Ц.Цэдэнжав нар: “Хилчид”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1950 он.
3. Н.Жамбалсүрэн: “Улаан Галстук”. Өвөр Монголын хэвлэлийн хороо. 1950 он.
4. Д.Нацагдорж нар: “Миний нутаг”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1953 он.
5. Ч.Чимэд нар: “Москвад Сталин минь байдаг”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1953 он.
6. М.Чимэд: “Анчин ба бүргэд”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1958 он.
7. М.Чимэд: “Хүүхэд тагтаа хоёр”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1959 он.
8. “Монголын шилдэг яруу найраг” (дээд, доод дэвтэр). Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1986 он.
9. Б.Явуухулан: “Б.Явуухулангийн шүлгийн түүвэр”. Өвөр Монголын сурган хүмүүмжлийн хэвлэлийн хороо. 1990 он.
10. Р.Чойном: “Сүмтэй бударын чулуу”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1991 он.
11. Р.Чойном: “Хүн”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1995 он.
12. Б.Лхагвасүрэн: “Уянгын тойрог”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1996 он.
13. “Монголын янагийн шүлгийн шилмэл”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1996 он.
14. Р.Чойном: “Уяхан замбулингийн наран”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1997 он.
15. “Монгол Улсын болор цом шагналт шүлгүүд”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1999 он.
16. Д.Пүрэвдорж: “Сэгс цагаан богд”. “Дэлхийн утга зохиол цуврал” найруулах хэлтэс. 2000 он.
17. Р.Чойном: “Улаан дэвтэр”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 2001 он, 2005 он.
18. Ж.Дашдондог: “Аранзал зээрд”. Үндэстний хэвлэлийн хороо. 2003 он.
19. Д.Пүрэвдорж: “Хялар хатан”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2003 он.
20. Ш.Дулам: “Тоглоё хоёул”. Цагаан шонхор номын өрөө. 2005 он.

21. Р.Чойном: “Хорвоод үлдэх дуун”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 2005 он.
22. Р.Чойном: “Хоноцын хүүхэд”. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 2006 он.
23. Б.Лхагвасүрэн: “Гашуун өвс”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2006 он.
24. “Халх бүсгүйчүүдийн хайрын шүлэг”. Үндэстний хэвлэлийн хороо. 2008 он.
25. Ш.Дулам: “Ш.Дуламын зохиолын түүвэр” (таван боть). Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 2009 он.
26. Ш.Дулам: “Сэнхэрэл уянга”. Төвийн үндэстний их сургуулийн хэвлэлийн хороо. 2010 он.
27. “Халх харчуулын хайрын шүлэг”. Үндэстний хэвлэлийн хороо. 2010 он.
28. “Очирбатын Дашбалбарын яруу найраг”. (хэвлэлийн хороо болон хэвлэсэн он жил байхгүй).
29. “О.Дашбалбарын яруу найраг”. (хэвлэлийн хороо болон хэвлэсэн он байхгүй).

Тав. Бусад зохиолын түүвэр:

1. “Д.Нацагдорж”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1955 он, 1957 он, 1979 он, 2004 он.
2. “Д.Нацагдоржийн зохиолууд”. Үндэстний хэвлэлийн хороо. 1955 он, 1989 он.
3. Д.Сэнгэ: “Үнэн”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1957 он, 2009 он.
4. “Ц.Дамдинсүрэнгийн зохиолын түүвэр”. Ляо Нингийн ардын хэвлэлийн хороо. 1958 он.
5. Д.Нацагдорж нар: “Шог хошин зохиолын дээж”. Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 1984 он.
6. Б.Бааст, Ж.Дооров нар: “Өгүүлэг найрууллууд”. Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 1986 он.
7. Ж.Дошдондог: “Морьтой үлгэр”. Үндэстний хэвлэлийн хороо. 2003 он.
8. Л.Түдэв нар: “Утгын чимэг”. Үндэстний хэвлэлийн хороо. 2004 он.
9. Ц.Дамдинсүрэн: “Буурал ээж”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2009 он.

1990 оноос хойш, манай оронд Монгол Улсын ном хэвлэлийн тархалт нь өрнөлтийн шатандаа орсон юм. Сүүлийн арваад жилд роман 13, тууж 32, өгүүлэл 478, шүлэг 935, найруулал 50, жүжгийн зохиол 8 хэвлэгдсэн байна. Үүнд Л.Түдэвийн: “Оройгүй сүм”, Ж.Пүрэвийн: “Манан будан”, Ж.Лодойн: “Дайн”, С.Удвалын: “Их хувь

заяа”, “Б.Явуухулангийн шүлгийн түүвэр”, Б.Лхагвасүрэнгийн: “Уянгын тойрог”, Ж.Доржийн “Эрдэнэ засгийн унага”, Р.Чойномын: “Хорвоод үлдэх дуун”, Д.Намдагийн: “Цаг төрийн үймээн”, С.Лочины: “Сарны гэрэл”, “Насны зам”, Д.Пүрэвдоржийн: “Сэгс цагаан богд”, Д.Намсрайн. “Хан уулын яргуй”, С.Пүрэвийн: “Цаг цагийн урсгал”, Ж.Пүрэвийн: “Хувилай хаан”, Б.Ринчингийн: “Заан Залуудай”, Ж.Бямбаагийн: “Энэрэлгүй хорвоо”, С.Эрдэнийн: “Амьдралын тойрог”, Д.Гармаагийн: “Янагийн халуун”, О.Дашбалбарын: “Бурханы мэлмий”, С.Дуламын: “Монгол бэлэгдэл зүй”, Ц.Билэгсайханы: “Ухаарахуй” зэрэг маш олон ном хэвлэгдэн гарсан байна.

Монгол Улсын нэгэн үеийн нэрт зохиолчдын ачаар, Өвөр Монголд дэлхийн уран зохиолын маш олон сонгодог бүтээлүүд кирил үсгээс уйгуржин монгол бичигт хөрвүүлэгдэн хэвлэгдсэн явдал нь манай орны утга зохиолын урын санд үнэлж баршгүй үнэт өв болон үлдсэнийг чухалчлан тэмдэглэх хэрэгтэй юм.

Ашигласан материал:

1. Цэнгэлтэй: “Монгол Улсад явсан тэмдэглэл”. “Өвөр монголын өдрийн сонин”. 1953 оны 2-р сарын 6-ны өдөр.
2. Манижав: “Монгол Улсын шинэ утга зохиол”. “Өвөр монголын өдрийн сонин”. 1953 оны 7-р сарын 11-ны өдөр.
3. Пэлиа: “Нацагдоржийн зохиолын сэдэв ба хэлний тухай шүүмж”. Өвөр Монголын “Өнөр цэцэг” сэтгүүлийн 1957 оны 2-р хугацаа.
4. И.Михайлов: “Орчин үеийн Монголын утга зохиолын түүхэн найруулал”. Пэлиа орчуулав. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1958 он.
5. Ц.Дамдинсүрэн: “Монголын уран зохиолын товч өгүүлэл”. Өвөр Монголын “Монгол түүх хэл бичиг” сэтгүүлийн 1958 оны 6-р хугацаа.
6. С.Өлзийбат: “Монголын идэр үеийн яруу найрагчдын уран бүтээл”. “Алтан түлхүүр” сэтгүүл. 1988 оны 6-р хугацаа.
7. Л.Батжаргал: “Ерээд оны Монгол Улсын уран зохиолдохь шинэ хандлага”. “Дэлхий утга зохиол” сэтгүүл. 1998 оны 4-р хугацаа.
8. Б.Цэцэн: “Монгол Улсын орчин үеийн уран зохиол номыг судлан ярилцах хурлын тухай”. “Өвөр монголын нийгмийн шинжлэх ухаан” сэтгүүл. 1999 оны 1-р хугацаа.
9. Сарнай: “Нийгмийн шилжилтийн үеийн Монгол Улсын уран зохиол”. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо. 2005 он
10. Ласагмаа: “Дундад Улс дахь Монгол Улсын орчин үеийн уран зохиолын судалгаа”. “Дундад Улсын монгол судлал” сэтгүүл. 2008 оны 5-р хугацаа.

11. Урнаа: “Монгол Улсын орчин үеийн утга зохиолын үндэслэгч Д.Нацагдорж”. “Монгол хэл утга зохиол” сэтгүүл. 1987 оны 1-р хугацаа.
12. Эрхэмбаяр: “С.Буяннэмэхийн яруу найргийн тухай үзэлт”. “Өвөр Монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл”. 2006 оны 5-р хугацаа.
13. Н.Улаан-Од, Мэнд нар: “Хятадын одоо үеийн монгол зохиолчдын өгүүллэгийн түүвэр”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1989 он.
14. Н.Улаан-Од: “Монголын зохиолч ба зохиол бүтээлийн танилцуулга”. Алашаны сонин 1991 он 1-р хуудас.
15. Н.Улаан-Од: “Монгол Улсын сонин сэтгүүлийн өгүүлэлийн гарчиг” (1965—1985) ном. Хөх хот. 1992 он.
16. Н.Улаан-Од: “Монгол Улсын уран зохиолын хөгжилт”. “Өвөр Монголын Хувь галуу сэтгүүл”. 2009 оны 8-р хугацаа.
17. Үнэнбат: “Дундад улсын Монгол судлалын ном зохиолын гарчиг” (1985—1990). 1992 он.
18. Үүлэнхуар: “Монгол судлалын монгол ном өгүүлийн хэлхээс” (1991—1995). 2005 он.